

ПРЕМИУМ НЭКСУС ХК



2026 ОНЫ 1-Р УЛИРЛЫН САНХҮҮ, ҮЙЛ
АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

ИРЭЭДҮЙГ ЧИГЛЭСЭН МЭДЭГДЛИЙН ТАЛААРХ АНХААРУУЛГА

Премиум Нэксус ХК нь энэхүү тайланд “ирээдүйг чиглэсэн” зарим мэдэгдэл агуулагдсан болно. Тухайлбал, тус тайланд “бид таамаглаж байна, бид тооцоолж байна, бид зорьж байна, бид төлөвлөж байна” гэх мэт үгстэй ойролцоо үг, мөн ирээдүй цагийг илэрхийлэх үгс ашиглагдсан болно. Ирээдүйг чиглэсэн мэдэгдэл нь ирээдүйд болох үйл явдал, нөхцөл байдлын баталгаа биш бөгөөд бидний таамагласан нөхцөл байдал биелэхгүй байх магадлалтай ба тэдгээр таамаглалуудад хэт найдах нь учир дутагдалтайг анхаарна уу.


Компанийн бизнесийн үйл ажиллагааны цаашдын чиг хандлага нь эрсдэл, тодорхойгүй байдал гэх мэт хүчин зүйлс, мөн үүгээр хязгаарлагдахгүй зүйлсээс хамаарч материаллаг зөрүүтэй байж болно. Тиймээс, эдгээр эрсдэл болон тодорхойгүй байдлыг харгалзан үзэж ирээдүйг чиглэсэн мэдэгдэл, төсөөллийг шууд утгаар нь бодитоор биелнэ хэмээн авч үзэх нь өрөөсгөл юм. Мөн, компанийн зүгээс шинэ мэдээ мэдээлэл болон ирээдүйд гарах ялгаатай үр дүн эсвэл аливаа бусад шаардлагын улмаас энэхүү тайланд тусгагдсан ирээдүйд чиглэсэн таамаглалуудыг шинэчлэх эсвэл засварлах аливаа үүрэггүй болохыг мэдэгдэж байна.

Агуулга

- Компанийн тухай 03
- CU Конвиниенс дэлгүүр 06
- 2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд 09
- Нэгтгэсэн санхүүгийн үзүүлэлтүүдийн товч танилцуулга 17
- Хувьцааны ханшийн хөдөлгөөн 20


Компанийн тухай

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН УДИРДЛАГА



Компанийн тухай

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН БИЗНЕСИЙН БҮТЭЦ



Компанийн тухай

Премиум Нэксус ЭКОСИСТЕМ Ба Түүний Давуу Талууд

Олон улсын стандартад нийцсэн хоол

Хоолны бүтээгдэхүүний гинжин хэлхээний бүх үе шатанд олон улсын стандарт, шилдэг туршлагад суурилсан хүнсний аюулгүй байдал, чанарын хяналтыг хэрэгжүүлж байна. Үүний үр дүнд үндэсний үйлдвэрлэгчид НАССР баталгаажуулалтад хамрагдаж, салбарын стандартыг шинэ түвшинд хүргэн, зах зээлд манлайлах боломж бүрдэж байна.

Логистик болон нэгдсэн түгээлтийн үр ашиг

Монголын дэд бүтцийн өнөөгийн нөхцөл байдалд бүтээгдэхүүний нийт өртгийн 30 орчим хувийг логистикийн зардал эзэлж байгаа нь дэлхийн дунджаас 2-3 дахин өндөр үзүүлэлт юм. Премиум Нэксус нь логистикийн дэд бүтцийн сайжруулалт хийснээр дээрх үр ашиггүй байдлыг арилгах болно.

Хөрөнгө оруулагчдын нэгдмэл ашиг сонирхол

СУ сүлжээ дэлгүүрийг түшсэн, түүнтэй хамаарал бүхий бизнесүүдийг нэг дор нэгтгэснээр тэдгээр бизнесүүд хамтын хүчээр үлэмж үнэ цэнийг бий болгох боломжтой. Ингэснээр хөрөнгө оруулагчид энэхүү синергээс бий болох бүх боломжийг хүртэх нөхцөл бүрдэнэ.

Байгал орчин, Нийгэм, Засаглалын өндөр стандарт өргөн цар хүрээ

СУ сүлжээ дэлгүүрийн ханган нийлүүлэгчид, ялангуяа жижиг дунд үйлдвэрлэгчид энэхүү эко-системд нэгдсэнээр, Премиум Нэксус ХК-ийн олон улсын жишигт нийцсэн БОНЗ-ын практикийг өөрийн үйл ажиллагаандаа нэвтрүүлэх боломж бүрдэнэ.

Үйлчлүүлэгчдийн сэтгэл ханамж

СУ сүлжээ дэлгүүр үйлдвэрлэгчидтэйгээ хамтран бүтээгдэхүүн хөгжүүлснээр хэрэглэгчдийн хэрэгцээнд бүрэн нийцсэн бүтээгдэхүүнийг үйлдвэрлэх боломж бүрдэнэ. Ингэснээр хэрэглэгчийн сэтгэл ханамжийг өндөр түвшинд хүргэх, үнэнч хэрэглэгчдийн тоог нэмэгдүүлэх боломжтой.

Ажилтнуудын өсөж дэвших боломж, сэтгэл ханамж

Монголын томоохон хөрөнгө оруулалтын компанийн нэг хэсэг болж ажиллах, групп компани дотроо өсөж хөгжих, Премиум туршлагаас суралцах зэрэг боломжууд ажилтнуудад нээлттэй болно.

CU Конвиниенс дэлгүүр

ПРЕМИУМ НЭКСУС ХК-ИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ

Хамгийн их сүлжээ дэлгүүртэй

2024 оны Монгол Улсын ТОП 100 аж ахуйн нэгж #7

Тэргүүлэгч жижиглэн худалдааны компани

Зах зээлийн үнэлгээ: 295 тэрбум төгрөг



Нэгтгэсэн нийт цэвэр борлуулалт
188+ тэрбум төг




Дэлгүүрийн тоо
557



Ажиллагсдын тоо
5,000+



Өдрийн хэрэглэгчдийн тоо
200,000+



Хамтран ажиллагч байгууллагууд
500+



Хувьцаа эзэмшигчид
9,960



+557 Дэлгүүрүүд
3,800+ Дэлгүүрийн ажилтнууд




Логистикийн бааз
120+ Логистикийн ажилтнууд



2 Түгээлтийн төв
240+ Ажилтнууд



Хоолны үйлдвэр
200+ Үйлдвэрийн ажилтнууд




Төв оффис
350+ Оффисын ажилтнууд

CU Конвениенс дэлгүүр

CU КОНВЕНИЕНС ДЭЛГҮҮРИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ГОЛ ҮЗҮҮЛЭЛТ


Үйлчлүүлэгчдийн тоо (сая)




Дэлгүүрийн тоо

	2025Q1	2026Q1	Өссөн дүн
УБ	397	456	+59
Орон нутаг	69	101	+32
Нийт	466	557	+91

Ажиллагсдын тоо



Дэлгүүрийн тоо



*Ажилласан хүний тоо буюу тухайн тайлант хугацаанд төлсөн нийгмийн даатгал төлөгчдийн тоо давхардаагүй дүнгээр.

CU Конвиниенс дэлгүүр

CU ХАРЬЦУУЛСАН БОЛОН НИЙТ ДЭЛГҮҮРИЙН ГҮЙЦЭТГЭЛ

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

2025 болон 2026 оны 1-р улиралд бүтэн үйл ажиллагаа явуулсан 427 дэлгүүрийн гүйцэтгэлийг харьцуулсан болно. Эдгээр дэлгүүрийн 2024 болон 2025 оны өдрийн дундаж үзүүлэлтүүдийг харьцуулахад үйлчлүүлэгчдийн тоо 7.6%-иар, өдрийн дундаж борлуулалт 7.1%-иар тус тус өсөж, худалдан авалтын дундаж сагсны дүн 0.5%-иар буурсан байна.

Харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэл

	2026 Q1
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	7.1%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	7.6%
Сагсны үнийн өсөлт	-0.5%

Харьцуулсан дэлгүүрийн тоо: 427

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

Харин уг үзүүлэлтийг бүх дэлгүүрийн хэмжээнд буюу 2024 оны 1-р улиралд ажилласан 446 дэлгүүр, 2025 оны 1-р улиралд ажилласан 557 дэлгүүрийг хамруулан тооцоход үйлчлүүлэгчдийн тоо 1%-иар буурсан боловч дундаж сагсны дүн 1%-иар өсөж, өдрийн дундаж борлуулалт өөрчлөлтгүй гарчээ.

Хурдтай нэмэгдэж буй шинэ дэлгүүрүүд нь бойжилтын хугацаанаас үүдэн системийн нийт дэлгүүрийн өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тоог бууруулдаг тул харьцуулсан дэлгүүрийн гүйцэтгэлээр дэлгүүрийн өсөлтийг хэмждэг.

Нийт дэлгүүрийн гүйцэтгэл

	2026 Q1
Өдрийн дундаж борлуулалтын өсөлт	0%
Өдрийн дундаж үйлчлүүлэгчдийн тооны өсөлт	-1%
Сагсны үнийн өсөлт	1%


Нийт дэлгүүрийн тоо: 446 → 557

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

Онцлох үйл явдлууд

- 20 шинэ дэлгүүр нээж, 8 дэлгүүр хааснаар нийт 557 дэлгүүртэй болсон.
- Улаанбаатар хотод 456, орон нутагт 101 дэлгүүр үйл ажиллагаа явуулж байна.
- Нийт 16 аймагт хүрээгээ тэлсэн.



	2025	2026Q1
CU дэлгүүрийн тоо	545	557

CU Конвиниенс дэлгүүр нь Монгол орныг зорин ирэх жуулчид болон нутгийн иргэдэд олон улсын стандартад нийцсэн үйлчилгээг хүргэхээр Улаанбаатар хотоос алслагдмал аймгууд болох Хөвсгөл, Баянхонгор, Дорнод аймгуудад шинээр салбар дэлгүүрээ нээн Монгол орны 16 аймагт үйл ажиллагаа явуулж байна. CU конвиниенс дэлгүүр нь үйл ажиллагаагаа Монгол орон даяар амжилттай тэлснээр бүс нутгийн эдийн засгийн хөгжилд хувь нэмэр оруулж, шинээр ажлын байрууд бий болгохын зэрэгцээ орон нутгийн иргэд, байгууллагуудтай хамтын ажиллагааг хөгжүүлж, хөгжил дэвшлийг хамтдаа бүтээх боломж бүрдэж байна.

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



- ХӨВСГӨР -

Хөвсгөр бууз, ороомгийн чанарыг сайжруулж, **ХӨВСГӨР** брэндийг дахин нэвтрүүлээ.



- ИЛҮҮ ТОМ ХАЗ- ХОТДОГ -

Бидний онцлог, брэнд бүтээгдэхүүнүүдийн нэг болох Хотдогийг бүтнээр нь шинэчлэн илүү том, илүү амттай болгож дахин нэвтрүүлэв.



- KFOOD Sensation -

Солонгосын алдарт гудамжны хоол болох догбугийг хялбар, шинэлэг аргаар болгон халуунаар нь идэх боломжтой боллоо.



- ХАЛУУН ТОГООНЫ АМТ -

Халуун тогооны амтыг хамгийн ойр CU-с мэдрэх боломжийг бүрдүүлж 4 төрлийн WOK хоолыг анх удаа танилцуулав.

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

CU КОНВИНИЕНС ДЭЛГҮҮР

ОНЦЛОХ БҮТЭЭГДЭХҮҮН



- CHERRY BLOSSOM SERIES-


Хаврын улирлыг угтан CU-д сакура цуврал нэмэгдлээ. GET кофе болон амтат бэйкери бүтээгдэхүүнээс бүрдсэн шинэлэг цувралыг нэвтрүүлэв.



- ГЭРИЙН ХҮНС -

Ам бүлтэй цөөн болон ганцаараа амьдардаг хэрэглэгчдэд зориулсан жижиг савлагаатай CU нэрийн хүнсний бүтээгдэхүүнүүд төрлөө нэмсээр байна.

Өндөг, сэндвич талх, сэндвич хам болон илүү өргөн сонголтыг CU-н салбаруудаас авч хэрэглээгээ хялбарчлах боломжтой боллоо.



- DAILY BAKED-

Өглөөний цай, үдийн амттан Daily Baked шинэ төрлүүдийг нэмж танилцууллаа.

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

СЭНТРАЛ КОММЕРС ХХК



ASAHI SUPER DRY X MANCHESTER CITY

Asahi Super Dry шар айраг нь Английн Manchester City хөлбөмбөгийн багтай хамтран ажилладаг ба Сэнтрал Коммерс ХХК нь Монголдоо анх удаа Manchester City кампанит ажлыг хэрэгжүүлж эхэллээ. Энэхүү кампанит ажлын хүрээнд олон төрлийн идэвхжүүлэлтүүд хийгдэж байгаагийн нэг нь 4 хэрэглэгчийг Английн Манчестер хотын Этихад стадионоос Premier League тоглолтыг үзэх эрхтэй сугалаат худалдаа юм.

Кампанит ажлын хүрээнд Монгол Улсад дараах идэвхжүүлэлтүүд хэрэгжиж байна:

- Asahi Super Dry х ManCity тусгай мерч бүтээгдэхүүнүүд
- Сугалаат худалдаа: Анлийн Манчестэр хотод Premier league тоглолт үзэх эрх - 4 хүн
- Erling Haaland-ын гарын үсэгтэй Manchester City багийн өмсгөл
- Сугалаат болон урамшуулалт хөтөлбөрүүд



CHINGGIS BEER X PRIMEAT CHEFS SPECIAL

Монголын шилдэг тогоочдыг алдаршуулах, тэдний тусгай хоолыг хэрэглэгчдэд амтлуулах улмаар рестораны соёлд үнэтэй хувь нэмэр оруулах зорилготойгоор Chinggis шар айраг нь Primeat брэндтэй хамтран "Chefs Special" уралдааныг эхлүүллээ.

Энэхүү уралдааны хүрээнд ахлах тогооч нар Chinggis шар айрагтай төгс зохицох Primeat махаар хийсэн нэрийн хоолыг танилцуулж менюндээ оруулж борлуулалтаараа өрсөлдөх ба борлуулалтын сувгийг дэмжиж оновчтой ажил болж байна.

ХООЛ, АМЬД ШАР АЙРГИЙН ТӨГС ХОСЛОЛ

Энэхүү уралдаан нь үндэсний брэндүүд болон ур чадвартай мэргэжилтнүүд хамтран үнэ цэн бүтээж болдгийг харуулсан үйл явдал юм.



CHINGGIS BEER LOYALTY

Chinggis Loyalty хөтөлбөрийн хүрээнд улирал бүр 45 харилцагчийг урамшуулж, идэвхжүүлснээр хамтын ажиллагааг бэхжүүлж, борлуулалтын тогтвортой өсөлтийг дэмжив. 2025 оноос эхэлсэн энэхүү хөтөлбөр нь хоёр дахь жилдээ амжилттай хэрэгжиж байгаа бөгөөд 2026 оны 1-р сард 2025 оны шилдэг харилцагчдыг тодрууллаа.

2026 оны Chinggis Loyalty хөтөлбөрийн хүрээнд дараах шинэчлэлтүүд хийгдэв.

- Харилцагчид өөрсдийн оноог хянах системийг нэвтрүүлснээр хүссэн үедээ өөрийн оноог харах, хянах боломжтой болсон
- Цуглуулсан оноогоо хүссэн үедээ зарцуулах, өөрийн оноонд таарсан бүтээгдэхүүнийг сонгон авах боломжтой болсон.

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

ЧИНГИС ШАР АЙРАГ ХХК



2026 оны 1-р улиралд Чингис Шар Айраг ХХК-ийн үйлдвэрлэл, үйл ажиллагаа тогтвортой, тасралтгүй явагдлаа. Үйлдвэрлэл төлөвлөгөөний дагуу явагдаж, бүтээгдэхүүнд чанарын хяналтыг тогтмол хийн бүтээгдэхүүний стандарт, шаардлагыг хангаж ажилласан. Мөн хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн шаардлагыг мөрдөж, ажилтнуудын ажиллах аюулгүй орчныг хангах чиглэлд тогтмол хяналт тавьж, ажилтнуудын мэдлэг, ур чадварыг нэмэгдүүлэх зорилгоор дотоод сургалт болон ажлын байрны зааварчилгааг тогтмол явуулж, байгууллагын дотоод үйл ажиллагааны уялдаа холбоо болон ажлын үр ашигт анхаарч ажиллалаа.

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

Сэнтрал Кофе Рөүстинг ХХК





2026 оны 1-р улиралд компанийн үйл ажиллагаа тогтвортой үргэлжилж, борлуулалтын үндсэн сувгууд дахь гүйцэтгэл хэвийн явагдлаа. Origin брэндийг жижиглэнгийн борлуулалтын сувгуудад нэвтрүүлснээр орлогын бүтэц төрөлжих суурь тавигдаж, хэрэглэгчдэд илүү ойртлоо. Кофены ногоон үрийн ах зээлийн хувьд түүхий эдийн үнийн хэлбэлзэл үргэлжилсэн хэвээр байсан ч ханган нийлүүлэлтийн стратеги болон зардалд нөлөөллийг зөв удирдаж чадсан. Цаашид компани нь өсөлтийн шинэ сувгуудыг хөгжүүлэх, зардлын үр ашигтай байдлыг хадгалах болон брэндийн байршуулалтыг бэхжүүлэхэд анхаарал хандуулан ажиллана.

2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

СТОРА ЦЕНТРАЛ ХХК

Стора Централ ХХК нь хэрэглэгчийн онлайн худалдааны платформ ашиглах мэдрэмжийг илүү хялбар болгох, хэрэглэгчийн цаг хугацааг хэмнэх зорилгоор худалдан авалтын зан төлөвөөр ангилсан системийн шинэчлэлт хийж Stora 2.1 хувилбараа танилцууллаа. Уг шинэчлэл хийгдсэнээр хэрэглэгчид Америк, Хятадын томоохон худалдааны платформуудаар худалдаалагдаж буй барааг ангилан харах, хамгийн ихээр захиалагдаж буй эрэлттэй бараануудыг харах, хэрэгэгчийн худалдан авалтын түүх дээр тулгуурлан бүтээгдэхүүн санал болгох функцүүдийн хөгжүүлэлтийг хийж, системийн интерфэйсийг илүү ойлгомжтой байхаар шинэчилсэн байна.



2026 оны 1-р улирлын онцлох үйл явдлууд

СТОРА ЦЕНТРАЛ ХХК

stora v.21
Илүү хялбар

🕒 03.25-04.10

stora v.21
Илүү хялбар

🕒 04.10 дуустал

stora
Үргэлж өөр

2XL - ТОМ ХЭМЖЭЭТЭЙ
СТОРАБОКСЫН БАЙРШИЛ

stora
Үргэлж өөр

Хүргэлтийн шинэ эрин

it's ALL INSIDE

it's ALL INSIDE

Эдийн засгийн хүндрэлтэй энэ үед Стора Централ ХХК нь өөрийн хэрэглэгчдээ илүү хэмнэлттэй худалдан авалт хийхэд нь дэмжлэг үзүүлэх зорилгоор 2026 оны 1-р улиралд Америкийн тээврийн үнийг 20%-иар хямдруулж, Хятадаас ирэх барааг үнэгүй тээвэрлэн хэрэглэгчийн гарт хүргэсэн бөгөөд энэ нь хэрэгцээт бүтээгдэхүүнээ гадаадаас илүү хямдаар захиалан авах, тээвэрлэлтийн зардлаа хэмнэх боломжийг олгосон үнийн бодлого байлаа.

Мөн CU-н сонгогдсон 12 салбар дэлгүүрт байрших Стора боксын хэмжээг томруулан хэрэглэгчид том овортой бараагаа Стора агуулахаас очиж авах бус өөрт ойр CU-н салбар дэлгүүрээс авах боломжийг бий болгов.

НЭГТГЭСЭН ОРЛОГО, ҮР ДҮНГИЙН ТОВЧ ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/	2024 оны 3-р сарын 31	2025 оны 3-р сарын 31	2026 оны 3-р сарын 31
Нийт цэвэр борлуулалт	110,927.5	152,195	188,937
Борлуулалтын өртөг	95,843.7	126,734	158,581
Нийт ашиг (алдагдал)	15,083.8	25,461	30,356
<i>Нийт ашгийн хувь</i>	3.6%	16.7%	16.1%
Үйл ажиллагааны зардал	4,226.0	7,930	11,105
ХТЭХӨАшиг	10,857.8	17,531	19,251
<i>ХТЭХӨАшгийн хувь</i>	9.8%	11.5%	10.2%
Элэгдэл хорогдол	7,961.6	9,848	14,243
Мөнгөн бус зүйлс - олз (гарз)	1,248.4	(103)	12
ХТӨАшиг	4,144.6	7,581	5,020
Санхүүжилтийн зардал	4,980.7	4,891	8,563
Татварын өмнөх ашиг (алдагдал)	(836.0)	2,690	(3,543)
Татварын өгөөж (зардал)	1.2	(81)	(148)
Цэвэр ашиг (алдагдал)	(837)	2,771	(3,395)
<i>Цэвэр ашгийн (алдагдлын) хувь</i>	-0.8%	1.8%	-1.8%

НЭГТГЭСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/	2024 оны 12-р сарын 31 /аудитлагдсан/	2025 оны 12-р сарын 31 /аудитлагдсан/	2026 оны 3-р сарын 31 /аудитлагдаагүй/
Эргэлтийн хөрөнгө	78,429	116,044	110,670
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	10,432	21,732	19,133
Дансны авлага	6,042	10,320	16,576
Бараа материал	47,195	67,460	54,304
Бусад эргэлтийн хөрөнгө	14,760	16,532	20,657
Эргэлтийн бус хөрөнгө	235,502	322,289	330,026
Биет болон биет бус хөрөнгө	157,907	229,177	218,226
Ашиглах эрхтэй хөрөнгө	60,569	79,127	78,591
Бусад эргэлтийн бус хөрөнгө	17,026	13,985	33,209
НИЙТ ХӨРӨНГӨ	313,931	438,333	440,696
Богино хугацаат өр төлбөр	116,242	166,442	158,101
Дансны өглөг	56,829	73,046	84,381
Богино хугацаат зээл	25,360	41,508	36,848
Бусад богино хугацаат өр төлбөр	34,053	51,888	36,872
Урт хугацаат өр төлбөр	94,900	157,664	179,300
Урт хугацаат зээл	23,888	79,300	101,233
Бусад урт хугацаат өр төлбөр	71,012	78,364	78,067
Эздийн өмч	102,789	114,227	103,295
Энгийн хувьцаа	111,425	111,425	111,425
Халаасны хувьцаа	-	(5,050)	(7,636)
Нэмж төлөгдсөн капитал	45,758	33,134	28,273
Эздийн өмчийн бусад хэсэг	319	319	319
Хяналтын бус хувь оролцоо	8,873	17,116	17,493
Хуримтлагдсан ашиг	(63,586)	(42,717)	(46,579)
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	313,931	438,333	440,696

НЭГТГЭСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Сая төгрөгөөр/	2024 оны 3-р сарын 31	2025 оны 3-р сарын 31	2026 оны 3-р сарын 31
Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	126,752	180,995	222,681
Мөнгөн зарлагын дүн (-)	(123,494)	(162,386)	(207,756)
Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	3,258	18,609	14,925
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	1,245	345	488
Мөнгөн зарлагын дүн (-)	(4,088)	(18,300)	(16,742)
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(2,843)	(17,955)	(16,254)
Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ			
Мөнгөн орлогын дүн (+)	8,276	115,100	139,785
Мөнгөн зарлагын дүн (-)	(5,778)	(120,012)	(141,024)
Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	2,498	(4,912)	(1,239)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн зөрүү	(28)	(23)	(31)
Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	2,885	(4,281)	(2,599)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	2,981	10,432	21,732
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,866	6,151	19,133

Хувьцааны ханшийн хөдөлгөөн

ПРЕМИУМ НЭКСУС ХК (CUMN):

2026 оны 3-р сарын 31-ний өдрийн байдлаар:

₮265

Нээлтийн ханш: 265

Нийт гаргасан хувьцаа: 1,114,252,034


Хаалтын ханш: 265

Эргэлтэд гаргасан хувьцаа: 1,114,252,034 52

долоо хоног: 180.05 - 335

Зах зээлийн үнэлгээ: 295,276,789,010

Индексжүүлсэн ханшийн гүйцэтгэл





Анхаарал
хандуулсанд
баярлалаа

Холбоо барих:
И-мэйл: investor@cumongol.mn